

ТӨРИЙН ХЭЛНИЙ БОДЛОГО ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙНА

С. Мөөмөө *

Орчин үеийн алимад хэлэнд тухайн нийгмийн амьдрал толь мэт тусгагдана. Үүнээс эгүүдэн хэлийг нийгмийн хөгжлийн барометр гэж хэлж болно. Үүнээс үзвэл хэл нь ард түмний өнгөрсөн, одоо, ирээдүй үеийг холбогч хамгийн амьд, тансаг холбоо хэлхээс, ястан, үндэстэн, угсаатны чухал шинжүүдийн нэг болж байдаг нь түмэн зүй мөн. Хэлний төрийн бодлогын мөн чанар нь тухайн хэлний өөрийн нь хөгжлийн дотоод хууль зүй, журам дүрмийг танин мэдэж зохицуулахад оршино. Хүн төрөлхтөн дэлхийн соёл иргэншлийн зүг чиглэсэн XX зууны тэргүүн хагасаас Монголд бүх зам тэр чиглэлээр, монгол хэл, үсэг бичгийг орчин үеийн шинжлэх ухааны үндэстэйгээр судалж эхэлжээ.

Дэлхий дээр таван мянга гаруй хэл, аялгуу байна. Зуу гаруй гишүүнтэй НҮБ-ын хүрээгээр авч яривал, орчин үеийн утга зохиолын 300 гаруй хэлнээс албан ёсны хэл англи, испани, орос, хятад, франц таван хэл байгаа бөгөөд ойрын үед нэмэгдээд нэмэгдээд энэ албан ёсны хэл 10-12-оос хэтрэхгүй гэсэн таамаглал байгаа юм. Үүний зэрэгцээгээр олон улсын соёл, шинжлэх ухааны харилцааны туслах зохиомол хэл интерлингва, окциденталь, эсперанто зэрэг хэл гарсан байна.

Орчин үеийн 2-3 утга зохиолын хэлний аль нэгийг авиан зүй, үг зүй, үгсийн сан, өгүүлбэрзүй, найруулга зүйн талаар төгс төгөлдөржүүлж авах уу гэдэг санал дэвшсэн байна.

Орчин үед дэлхийн улс түмний олон хэл нь шинжлэх ухаан, техник соёл иргэншлийн хамтын ажиллагаанд нэг саад тотгор болж, хүн төрөлхтний үйлдвэрлэх үйл ажиллагаа, хүн хүч, цаг хугацааны их хохирол, бэрхшээл учруулж байгаа нь хэн бүхэнд хэлүүлэлтгүй ойлгомжтой билээ. Ганц жишээ дурдахад, 1652 хэл аялгуутай Энэтхэгт Конгресс нь Үндсэн хуулиар 15 хэлийг албан ёсны хэл хэмээн баталгаажуулжээ.

Монголд бас тогтсон уламжлал байсан юм.

Хубилай цэцэний үед хааны засаг, номын засаг гэж байлаа. Төрийн хэлний бодлого нь ихээхэн өргөн цар хүрээтэй асуудал юм. Төр засаг, сургууль, соёл, урлаг, уран зохиол, хэвлэл радио, телевиз, театр, кино, шинжлэх ухааны олон салбар түүх, гүн ухаан, хэл шинжлэл зэргээр хүний ухамсартай үйл ажиллагаа хэл бичигтэй гүнзгий холбоотой нь мэдээж.

Нөгөөтэйгүүр уран зөв хэлэх, бичгийн ур эрдэм гэж байх мэт. Хэлний хөгжлийг төрөөс жолоодох ойрын болон хэтийн бодлогын асуудлаар санал дэвшүүлэн ярилцах

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Хэл шинжлэлийн тэнхим

цаг нэгэнт болжээ. Дэлхийн олон хэлний чиг хандлагын тухай дээр цухас дурдсан. Орчин үед өндөр хөгжил, соёл иргэншилтэй гэгддэг орнуудад биологи, математик, хими, физик, хэл шинжлэлийн салбарт үгсийн сангийн хэдэн сая нэр томъёо тогтоон хэрэгжүүлж байгаа нь бидний ярилцах асуудлын зөвхөн нэг тал болох юм. Нэг үгээр хэлэхэд голлох том хэлүүд нь бага буурай цөөн тооны Будух, Хиналуг, Бацбий, Ливи зэрэг бичиг үсэггүй айлын гэмээр жижиг хэлүүдийг том хэлэндээ шингээх чигтэй болж байна.

Монгол Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн дарга, Ерөнхий сайд, Улсын Бага Хурлын дарга агсан, манай үеийн их бичгийн хүн, эрдэмтэн, төрийн зүтгэлтэн А.Амар гуай “Ардын үндэсний эрх” сонинд 1933 оны нэгдүгээр сарын 14-ний №3-т “*Монгол үндэсний хэл бичгийг хөгжүүлэх тухай сэдэв*” хэмээх өгүүлэл хэвлүүлсэн нь тэр үеийн оюутан, сэхээтэн, хожим манай алдарт эрдэмтэн, академич болсон Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Б.Ринчен нарын зэрэг залуучуудын урам зориг, оюун санааг эзэмдэн сэргээж үлгэрлэн дагуулсан билээ.

Зохиогчоос монгол үндэсний хэл бичгийг хөгжүүлэх тухай сануулан бичсэн сэдэв бол өөрийн үндэсний хэл бичгийг бататган бэхжүүлэхэд холбогдсон улс төрийн соёл боловсролын нэгэн чухал зүйл болно. Иймийн тулд энэхүү монгол үндэсний хэл бичгийг бататган хөгжүүлэх, түүний зохиолыг Ардыг Гэгээрүүлэх Яам ба Шинжлэх ухааны хүрээлэнгээс толь бичиг зохиох болон боловсрол гэгээрлийн ба олон сургуулиудад заах зүйлд гарын авлага болгон гүйцэтгэх болсон. Үүнчлэн үндэсний олон оюутан нараас монгол үндэсний хэл бичгийг бататгах ба дэлгэрүүлэх тухай зохиол саналуудыг гаргаж хөгжүүлэх нь чухал болохыг төрөөс тэмдэглэсэн баримт олон бий. Мөн гадаадын хэлнээс шинэ зохиол гарах болж Шинжлэх ухааны хүрээлэнд нэг жилээс илүүгүй хугацаанд зохиолгож гаргах, хэвлэн гүйцэтгэхийг даалгасан байна.

Монголын хуучин шинэ үгүүд ба одоо үед ард олноор хэлэлцэж буй бүхий л үгнүүдийг хураангуйлан зохиож, энэхүү дэвтэрт хэвлэн нийтлэх аваас монгол үгийн баялаг нэмэгдэж, утга чанар төгсөх бөгөөд ард нийтээр өөрсдийн хэл үгийн баялаг өргөн ба утга чанар лугаа танилцаж, оюун ухаан нь нэмэгдэн нээгдэж улмаар хэл бичгийн боловсролыг хөгжүүлэх болно.

Нийтийн боловсролоос хоцорсон Монголын олон түмэн ардууд нь өөрийн үндэсний хэл бичгээр дэвсгэр тавьж, Европ дахины шинжлэх ухааны эрдэм ба хувьсгалын суртал боловсролыг өөрсдийн үндсэн бичиг хэлнээ зөвөөр буулган авах ба суралцаж боловсроход түргэн дөхөмтэй болно. Үндэсний үсэг бичиг, үг хэлийг хөгжүүлэхэд басхүү сурлага хичээл ба албан бичиг явуулах талаар чухал болговол зохих бөгөөд улсын хэвлэлийн газрууд ба албан хаагчид, багш нар, сурагчид, оюутан нийтээр даалгаж, аливаа хэвлэх машиндах буюу гараар бичих ба заах суралцахад эрх биш үсэг тутам дүрэмтэйгээр явуулж, үндэсний бичиг хэлийг улмаар бататган хөгжүүлэх ба бичиг үсгийг хэрхэн бичих зурах тухай хичээл сурлагыг сайжруулж хэлбэр дүрсийн талаар язгуур гоёмсог үзэмжтэй бичих заншлыг нэгэн адил хөгжүүлэх нь чухал болно. Хэлбэр дүрсийг зөвөөр бөгөөд үзэмжтэйгээр бичих, зохион хэвлэн нийтэлсээр иржээ.

А.Амар гуай цааш нь “... Манж чин улсын сүүлчийн үед Монголын хэл бичигт манжийн төрийн хортой бодлого биетэйгээр нэвтэрч, монгол үндэсний хэл бичгийг шууд мөхөөх балрах зам руу хандаж байсан бөгөөд монгол үндэсний хэл бичгийг мөхөөх манжийн гол зэмсэг нь лалын шашин, түүний тоо томшгүй олон лам нар, Хятадын нүүдлийн иргэдийг түлхэн оруулж Монгол газрыг эзлэн авах явдал болсон юм. Шинжлэх ухааны хүрээлэн, дуун ухааны тасгийн хийсэн гавьяат ажил нь Азийн номын

сан бөгөөд үүнд Монголын хуучин сурвалж бичиг, бараг дэлхий дээр хосгүй ховор нандин эрдэнэ хадгалагдаж байгаа юм. Бид Монгол Ард Улсыг мандуулахад Монголын ард түмэнд өөрсдийг харах тольгүй байна. Юуны өмнө ард олныг бичиг үсэгт сургах, шилдэг зохиолыг шилж орчуулах, энэ хэрэгт оролдмоор хүмүүсийг шилж олох, хамгийн тэргүүнд бага насны хүүхдийн унших бичиг хэвлүүлэх, юуны өмнө олон зүйлийн ухааны нэр томъёог боловсруулан тогтоох нь чухал юм. Монголын хуучин соёлын дотроос өв болж бидэнд үлдсэн хуучин бичгийн хэл, одоогийн амьд хэлийг судлах, улмаар найруулгыг сайжруулж, ялдам яруухан болгох, үүнд наран ургасан боловч сүүдэр бас л оршсоор байна. Бичгийн хэлийг олонд ойлгомжтой болгох нь зүйтэй байна. Бичгийн хэл бол манай ардын гартаа барьж мордох чухал зэвсэг юм. Хэрэв энэ зэвсэг болхи болбоос тугалган сүхтэй түлээнд гарахтай адил юм. Одоо манай бүх ардын зууны ерэн хувь нь бичиг мэдэхгүй, дөнгөж арван хувь нь бичиг мэдэх төдий болох нь үндэсний бичиг үсгийн сурлагыг аяндаа шаардаж буй хэрэг мөн тул дуун ухааны хэргийг эрхлэх тусгай тасгийг байгуулж, Монгол улсын хөгжилтөөр шаардагдаж бүхий дуун ухааны талаар холбогдох бүхий л асуудлуудыг судлан боловсруулж, дэлгэрүүлэн хөгжүүлэх замаар манай улсын урагш хөгжин боловсрох явдал дээр дуун ухааны талын бүхий л ажлыг бусад хөгжлөөс хоцрогдуулалгүй нэгэн адил хөгжүүлэх үүргийг хүлээлгэжээ. Учир иймийн тул бид нар нам засгийн бодлого хэргийг ард олны дунд биелүүлэн гүйцэтгэхдээ эрхбиш урьдаар ард олны байдлыг засаж сайжруулж, бичиг үсэгт сургах хэрэгтэй бөгөөд тариа тарих дур урьдаар газрыг засах хэрэгтэй. Түүнчлэн нам, засгийн ажил хэргийн урсгалыг явуулахуй дур ард бүхнийг үндэсний хэл бичиг, үндэсний мэдрэлтэй болгох чухал болмуй. Үндэсний бичиг үсгийг сурч мэдэх явдал нь боловсрол бүхний үндэс суурь дэвсгэр ба үүд хаалга нь мөн бөгөөд өөрийн улс гэр, ард түмний хэрэг ажлыг удирдан явуулж чадах чадвар бүхий болмуй” гэх зэргээр дурдсан байна.

1933 оны дөрөвдүгээр сард “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл”-ийн нэгдүгээрт Монгол Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгээс оршил болгон “Хэлний засгийн учир” өгүүлэл нийтлүүлсэн. Түүнийг сийрүүлбэл, “Хэлний засаг хэмээгч нь шинэ нэр болой. Монголын хувьсгалаас олонд ихэд алдаршсан эдийн засаг хэмээх нэрийг үлгэрлэн зохиов. Тайлбарлабасу, улиран хувьсч боловсрох явдлыг улс гэрээс хянан шинжилж, удирдан засах заслыг хэлэлжүүхүй, зарим этгээд улс төрөөс тийнхүү хэлний засгийн бодлогыг явуулж болохгүй, хэлний хөгжих дэлгэрэх, буурах эвдрэх нь цөм өөвсөөн хувьсан улирмуй. Ер хүний санаа зоригийг дагах нь бус хэмээмүй. Энэ нь ташаа болой. Хэлийг судлах шинжлэх ухаан буй нь тусгайлан хэлний дүрэм, зүйг шинжиж, улирах хөгжих, жам мөрийг судалмуй. Тийнхүү шинжлэн магадалснаар хэлний улирах хөгжих зүй байдлыг хянан засаж, удирдан залж болох ажгуу.

Орчин үеийн монгол хэлний байдлыг анхааран үзбэсү зохиол, найруулга, орчуулга, нэр томъёо зэргийн маш олон зүйлд хянан засаж, шинжлэн залахгүй болбасу болохгүйд хүрсэн байдал зүйл зүйлээр илтгэгдсэн буй тул улс гэрийн соёлыг өрнүүлэн хөгжүүлэхийг эрхэм хүнд болгож буй энэ үеэс хэлний хувьсан улирах зам мөрийг хянан шинжилж, залан удирдах явдал маш чухал болбай. Улсын олон сэхээтэн ард нэгэн санал нийтийн хүчээр энэ зүг хандах цаг тулгаран иржээ хэмээн манай хүрээлэнгээс залуу оюутан Дамдинсүрэнгийн зохион бичсэн хэл бичгийн тухай өгүүллийг эгүүнээ нийтэлбэй. Жич: Зохиолын дотор эш татаж хэрэглэсэн зүйлийн зарим нь хэдий өнгөрсөн жилүүдийн өнгөрсөн хэргийн доторхи зүйл хэмээвч түүний адил зүйл нь эдүгээ ч хэл бичигт үзэгдсээр буй тул хэрхэн хуучран өнгөрөв гэнэм.

Манай хүрээлэнгээс үндэсний хэл бичгийг өрнүүлэх хэлний засгийн бодлогын зүйлийг үүнээс хойш үргэлжлэн нийтэлмүй. Уншигчид анхааран сонирхож энэ зүг санааг адбиш тавих буй за. Монгол Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэн” гэжээ.

Үүнээс үзвэл “Хэлний засгийн учир” өгүүллийг Ц.Дамдинсүрэн гуай бичээгүй нь тодорхой байна. Яг гуравхан сарын өмнө А.Амар гуай “Монгол үндэсний хэл бичгийг хөгжүүлэх тухай сэдэв” зохиолоо “Ардын үндэсний эрх” сонинд хэвлүүлсэн тухай дээр товч өгүүлсэн. Мөн эл дугаарт Б.Ринчен “Орос хэлийг цэвэрлэн ариутгах тухай” өгүүллийг орчуулан нийтлүүлжээ. Энэ үед А.Амар гуай Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн дарга байсан болов уу. 1930, 1940-өөд онд Шинжлэх ухааны хүрээлэн, хуучны монгол үсэгт шинэчлэлт хийх, латин үсэг, оросын шинэ үсгийг монгол хэлэнд зохицуулах ийм гурван хувилбартай чиглэл даалгавар авахдаа юуны өмнө тус орны ард иргэдийг аль болох түргэн хугацаанд бичиг үсэгтэй болгож, дэлхийн соёл иргэншлийн зүгт хандуулах чиг давамгайлсан юм.

Я.Цэвэл гуайн удирдлагаар нэгдүгээр ангид орох насны хэдэн хүүхэд авч, хуучин монгол, латин, шинэ гурван үсгийн хичээлийг нэгэн зэрэг зааж, тодорхой хугацаа өнгөрсний дараа шалгалт авчээ. Комисс, хүрээлэнд явуулсан дээрх туршилтын дүнтэй танилцсан байна. Үгийн эхэн, дунд, адагт гэж ялгадаг 100 гаруй үсэг сурах, 20-30 гаруй үсэг сурах хоёр адил байна гэдэг бол хүн үнэмших аргагүй зүйл юм. Ингээд эцсийн эцэст орос үсэг сонгон авсан юм. Энэ нь улс үндэстний язгуур эрх ашиг, соёл иргэншилтэй нягт холбоотой үсэг бичгийн хувь заяаны асуудалд богинохон настай хууль, тогтоол гаргаж болохгүй гэдэгт чухал сургамж болсон байна. Сүүлийн үед дахин латин үсэг заах, сурах төсөл эрч хүч авч байгаа бололтой. Ард түмэн үг хэллэг, үсэг бичгээ хэрэглэх хөгжүүлэх эрхийг үл тоомсорлон, хэсэг бүлэг хүмүүс хүчээр түрэмгийлэн, ард түмний цорын ганц өмчид өнгөлзөх оролдлого нь өргөн олны шаардлага, санал, социологийн судалгаатай мөргөлдсөөр байгаа нэн цөөнхийн болчимгүй түр зуурын чанартай хийрхэл мөн.

Төрийн хэлний бодлогод холбогдох зарим санаа

1. Өлгийтэй хүүхдийн хэлний учир

Хүүхэд өлгийтэй байхаасаа эхлэн хэл сурдаг. Энэ үеийн хэлний багш нар нь тэдний эцэг эх, ах эгч орчин нь юм. Өөрөөр хэлбэл гэр бүл юм. Тэгэхээр нялхсын хэлний багш болж байгаа эцэг эх, ах эгч нар эх хэлээ хэр анхаардаг вэ? Залуу эцэг эхчүүд төрсөн хүүхдээ чухам хэдэн настайдаа ямар үгээр хэлд орсон, хэдэн настай хөлд орсон, хэдэн үг мэддэг гэхдээ ямар ямар үг сурдаг болохыг ажигладаг билүү? Зарим оронд шинжээчдийн хийсэн судалгаанаас үзвэл 1-3 хүүхэд аав, ээж, эмээ, өвөө, сайн, муу, хоол унд гэх мэт 25-60 үг мэддэг гэж тодорхойлж байна. Тэр ч байтугай аятайхан хөг аялгаар бүүвэйдэг билүү ч зэрэг асуудал тавьж болох юм.

2. Сургуулийн өмнөх насны буюу цэцэрлэгийн хүүхдийн хэл

Энэ насны хүүхдийн хэл нь өлгийтэй хүүхдийн хэлнээс урагш давшиж, үнэндээ тоглоом наадгайтай холбоо бүхий үгээр баяжиж ирнэ. Энэ үед асрагч, хүмүүжүүлэгч аав, ээж гэр бүлийн хүмүүсийн хамтарсан хэлний үйл ажиллагаа эрчимжих бөгөөд өдрөөс өдөрт шинэ шинэ үг сурах явц үргэлжилнэ. Ажиглавал тэдний үгэнд хараалын муу үг нэвтрэх байдал нэвтрэх байдал ихсэх тал нэлээд байна. Үүнд:

Хүмүүжүүлэгч багшийн хэлний боловсрол чухал нөлөө үзүүлдэг билээ.

3. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хэл

Сургууль гэдэг нь хэрэг дээрээ багачуудын шинэ ертөнц юм. Энд сурагчид нийгэм, байгалийн шинжлэх ухааны арвин мэдлэгийг сурч эхлэх онцлогтой юм. Сургуулийн буюу албаны, багш нарын хэл өдөр тутмын амьдралын нэг талыг захирч эхэлнэ. Өөрөөр хэлбэл төрөл бүрийн хичээлийн танхимын хэл гэж хэлж болохуйц хэл зонхилдог байна.

Бичиг зохиолын хэл хичээлийн дэвтрээр гол болгосон ном бичгийн хэл болно. Утга зохиол, бичгийн хэлээр дээр дурдсан өлгийн, сургуулийн өмнөх насны хүүхдийн хэлийг захирсан шинжтэй үнэндээ тэдний арваад жилийн хэл юм. энэ үед л бидний бодлоор хүүхдийн хэлний боловсрол тогтож төлөвших үе болно. Манай ЕБС-ийн олон мянган сурагчдын хэл ямар байдалтай байна вэ? Энэ талаар судалгаа хийгдээгүй явсаар байна. Энэ үеэс нөгөө сурч байгаа хэлээ эх хэлтэйгээ хутгаж эхлээд цааш их, дээд сургуульд үргэлжлүүлдэг биз дээ, магадгүй багш нар ч хольж хутгаж ярьдаг. Нэг үе орос хэл, одоо англи мэт гадаад хэл зонхилох болов.

4. Их дээд сургуулийн оюутны хэл

Тэд орчлон дэлхийн учрыг ойлгох хүслэнд автагдаж олон хэл сонирхож эхэлнэ. Ингээд эх хэлнээсээ гадаад хэлийг дээгүүр үзэж, монгол хэлээ голох гэнэн хонгор сэтгэлгээнд автагдаж ирнэ.

5. Төрийн байгууллагын ажилтны хэл

Олон нийтийн байгууллага тухайлбал, хэвлэл мэдээлэл, радио, телевиз, кино, театрт ажиллагсад, албан хаагчид албан харилцааны хэлийг судлах шаардлагатай болж байгаа юм.

Монгол улсын Үндсэн хуулийн I бүлгийн 8-р зүйлд:

“Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн” гэж заажээ. Тэгвэл өнөөдөр байдал ямар болоод байна гэвэл холимог эрээн мяраан үг хэллэг Улаанбаатарт эрээлжлэх болжээ. “Өнөөдөр”, “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сониноос эхлэн бусад сонин сэтгүүл үгийг эмх замбараагүй хэрэглэх болжээ. Жишээ нь: Улаанбаатар хотын гудамж, байр, үйлчилгээний газар bar, night club, casino, bridge, shop, paradox, spiker, ломбард гэх мэт үгс олноор үзэгдэх болсон байна.

Энэ талаар төр засаг, Улаанбаатар хотын засаг дарга, боловсролын газар цэгцтэй ажил зохиох цаг тулгарсан байна.